МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 26 өдөр Дугаар А/468 Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 35 дугаар зүйлийн 35.2, 40 дүгээр зүйлийн 40.3, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 85/А2270438/-НАГ/-2019/07/-НА дугаартай албан шаардлагын дагуу Мөрөн сумын 1 дүгээр баг баярын талбайн хойд талд "Хотол даян" ХХК-д үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар 800 /0.08/ м^2 газрыг төрийн байгууллагын газраас үнэ төлбөргүйгээр газар эзэмших эрхийг хэсэгчилэн шилжүүлсэн нь Газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн тул аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А/258 шийдвэрийн 2 дахь хэсгийг хүчингүй болгож, газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Дээрх захирамжийн дагуу Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, захирамжийг холбогдох этгээдэд танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, баримтыг бүрдүүлэн ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийг эс зөвшөөрвөл захирамж гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

6710011762